
**Сovid-19 халдвартай тэмцэх
хөгжлийн хамтын ажиллагааны
АВС хөтөлбөр**
[**A**genda for **B**uilding resilience against **C**ovid-19
through Development Cooperation]

2020. 4. 13.



Онцгой байдлын менежментийн стратеги ТГ

Агуулга

I.	Нөхцөл байдлын шинжилгээ	
	1. Гадаад дотоодын орчны өөрчлөлт.....	1
	2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлага.....	2
II.	Covid-19 халдвартай тэмцэх хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөр (ABC)	
	1. Хөтөлбөрийн танилцуулга.....	3
	2. Нарийвчилсан хөтөлбөр.....	5
	① Зорилтот улс орнуудын Эрүүл мэндийн салбарт дэмжлэг үзүүлэх.....	5
	② Хөгжиж буй орнуудын халдварт өвчний менежментийн чадавхыг бэхжүүлэх.....	7
	③ БНСУ-ын туршлагыг ашиглан олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх.....	8
III.	Жил бүрийн ажил хэрэгжилтийн нарийвчилсан чиглэл	
	1. [Богино хугацааны] 2020онд авах шуурхай арга хэмжээний төлөвлөгөө.....	9
	[Хавсралт 2] 2020оны шуурхай арга хэмжээний хөтөлбөрийн үндсэн агуулга.....	15
	2. [Дунд болон урт хугацааны] Цаашид хэрэгжүүлэх чиглэл.....	52

I. Нөхцөл байдлын шинжилгээ

I. Гадаад дотоодын орчны өөрчлөлт

[Хохирлын нөхцөл байдал] COVID-19 халдварыг цар тахлын хэмжээнд хүрсэн гэж зарласнаас хойш дэлхийн нөхцөл байдал хүндэрсэн

- 4-р сарын 11-ний байдлаар дэлхийн 215 улс, 1,640,954 хүн энэхүү халдварт өвчинг туссан бөгөөд цаашид тоо нь өссөөр байна.
- Тэр дундаас халдварт өвчний эсрэг тогтолцоо муутай хөгжиж буй орны хувьд COVID-19 халдварт өвчин хүчтэй нөлөөлөлөх магадлалтай.

[Олон улсын байдал] БНСУ хариу арга хэмжээг амжилттай үзүүлэн түүнийг загвар болгосноор олон улсаас тусламжийн хүсэлт ирж байна.

- G20 дээд хэмжээний уулзалт(3.27)-ын үеэр БНСУ-ын засгийн газар нээлттэй · ил тод · ардчилсан байдлыг сахиж COVID-19-тэй тэмцэх чиглэлийг санал болгосон.
 - БНСУ-ын амжилттай үзүүлсэн хариу арга хэмжээг загвар болгон бусад улстай хуваалцах
 - Эрүүл мэндийн салбарын хөгжил муу улсуудад дэмжлэг үзүүлэхийн тулд хамтран ажиллах
 - Хөгжиж буй улсын халдварт өвчинтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх
- 20 улсын дээд тэргүүнүүдтэй COVID-19-ийн талаар хэлэлцэж байгаа бөгөөд одоогоор 120 улсаас оношлогооны төхөөрөмж болон хүмүүнлэгийн тусламжийн хүсэлт ирж байна.
- ДЭМБ-аас БНСУ-ыг Дэлхийн эрүүл мэндийн ассемблей дээр өөрийн улсын туршлагын талаарх илтгэл тавихыг хүссэн.(4.6)

[Дотоодын байдал] COVID-19 халдварт өвчний эсрэг арга хэмжээ авах болон дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.

- COVID-19-ийн эсрэг яаралтай арга хэмжээ авах болон дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах мөн халдварт өвчингүй болсон дараах үед хөгжлийн хамтын ажиллагааны чиглэлийг гаргах тал дээр бодолцох хэрэгтэй.
- Олон улсад дэгдэж буй энэхүү халдварт өвчинтэй тэмцэх, хүний аюулгүй байдлыг хангасан ODA төслийг хэрэгжүүлэх талаар бодолцож үзэх.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлага

□ Шаардлага

[Үнэ цэнэ : Глобал халдварт өвчинтэй тэмцэх, хэн ч гадуурхагдахгүй хөгжлийн хамтын ажиллагаа хэрэгтэй]

● COVID-19-тэй адил глобал халдварт өвчний улмаар KOICA-гийн 4P-д тулгуурласан хөгжлийн хамтын ажиллагааны ач холбогдол дахин тодорч байна.

- (People) Гадуурхагдсан хэн нэгний халдварт өвчин миний асуудал болон хувирах

- (Peace) Цар тахлын нөхцөл байдал нь энх тайвантай шууд холбоотой

- (Prosperity) Зөвхөн нэг улсын хөгжил биш хамтдаа хөгжих гэдгийг ойлгох

- (Planet) Байгаль орчинг сүйтгэх нь шинэ халдварт өвчинг үүсгэнэ гэдгийг ойлгох

● Хил дамжин тархаж буй энэхүү халдварт өвчний эсрэг улс орнууд хамтдаа тэмцэх, мөн хөгжиж буй орнуудын хувьд хөгжлийн хамтын ажиллагааг баримтлах нь чухал

[Эв нэгдэл : G20 дээд хэмжээний уулзалтын үеэр COVID-19 халдварт өвчний эсрэг олон улсын хамтын ажиллагаа зохион байгуулахаар гарын үсэгээ зурсан]

● Олон улсын хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлэх үүднээс KOICA-гийн туршлагыг ашиглан хөтөлбөр боловсруулсан.

<Засгийн газрын тогтолцоог тусгасан KOICA-гийн хөтөлбөр>

Засгийн газрын G20 тунхаглал
Эрүүл мэндийн салбарт зорилтот улс орнуудад хамтын ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх
Хөгжиж буй орнуудын халдварт өвчинтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх
БНСУ-ын амжилттай туршлагыг бусад улстай хуваалцах

KOICA-гийн хөтөлбөр
Зорилтот улс орнуудын Эрүүл мэндийн салбарт дэмжлэг үзүүлэх
Хөгжиж буй орнуудын халдварт өвчний менежментийн чадавхыг бэхжүүлэх
БНСУ-ын туршлагыг ашиглан олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх

[Хамтдаа бүтээх : Хөгжиж буй орнуудын халдварт өвчинтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх & дотоодын био эрүүл мэндийн аж үйлдвэрийг экспортлох]

● Хөгжиж буй орнуудад хүмүүнлэгийн тусламж үзүүлснээр олон улсын хандивлагч орны үүргээ гүйцэтгэж оношлогооны төхөөрөмжөөр хангах, халдварт өвчинтэй тэмцэх тогтолцоо болон системээр хангах зэрэг нь дотоодын био эрүүл мэндийн аж үйлдвэрийг олон улсад таниулахад түлхэц болж өгнө.

- Нэг улсын хөгжил цэцэглэлээс тэлж хамтдаа сайхан амьдрах, хамтын хөгжил цэцэглэлийг бий болгох, хөгжлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх нь чухал.

II. COVID-19-тэй тэмцэх хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөр(ABC)

I. Хөтөлбөрийн танилцуулга

□ Ерөнхий бүтэц

[Хөтөлбөрийн нэр] Хөгжлийн хамтын ажиллагаагаар дамжуулан COVID-19-ийн эсрэг тэсвэртэй байдлыг бий болгох хөтөлбөр

Agenda for

Building Resilience against

COVID19 through development cooperation(Товчлол ABC хөтөлбөр)

[Уриа] Save Lives, Save Livelihood

[Үндсэн сэдэв] Үндсэн 3 чиглэл

	Response (2020-2021)	Resilience (2022-2024)
Зорилтот улс орнуудын Эрүүл мэндийн салбарт дэмжлэг үзүүлэх (Action to Fragility)	- Оношлуураар хангах - Эм, вакцин гарган авах - Зорилтот бүлэгт хүмүүнлэгийн тусламж үзүүлэх	- Оношлох технологийн чадавхыг нэгтгэх - Эм болон вакцинаар хангах - Зорилтот бүлгийн нөхөн сэргэх чадавхыг бэхжүүлэх
Хөгжиж буй орнуудын халдварт өвчний менежментийн чадавхыг бэхжүүлэх (Building Capacity)	- Халдварт өвчнөөс сэргийлэх сургалт зохион байгуулах - Халдварт өвчнийг урьдчилан шинжлэх чадавхыг бэхжүүлэх - Халдварт өвчинд түргэн арга хэмжээ авах суурийг бий болгох	- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төслийг бүрдүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх - Халдварт өвчнөөс урьдчилан шинжлэх төслийг бүрдүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх - Халдварт өвчинд арга хэмжээ авах төслийг бүрдүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх
БНСУ-ын туршлагыг ашиглан олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх (Comprehensive Cooperation)	- Дотоодын халдварт өвчинд авах арга хэмжээний туршлага судлах - COVID-19-тэй тэмцэх олон улсын иргэний хамтын ажиллагааг сайжруулах - Дотоодын дэдшилтэт технологийг илрүүлэх, тэлэх	- Нийлмэл шинжтэй халдварт өвчний судалгаа шинжилгээг сайжруулах - Олон улсын иргэний хамтын ажиллагааг идэвхжүүлэх - Дотоодын дэвшилтэт технологийг ашиглан хөгжиж буй орнуудыг дэмжих

[Үндсэн санаа] COVID-19 STOP зарчим X STOP үйлдэл

STOP зарчим	STOP үйлдэл
Solidarity (Нийгмийн болон олон улсын эв нэгдэл)	Speed (Түргэн шийдвэр гаргах, түргэн үйлдэл хийх)
Trust (Нийгмийн итгэлцэл)	Transparency (Ил тод бодлого, засаглал)
Ownership (Өөриймсөг хандах хандлага)	Openness (Мэдээллийн хөгжүүлэлт)
Partnership (Түншлэл)	Participation (Оролцохыг уриалах)

[Зорилт] Хөгжлийн хамтын ажиллагаанд суурилан COVID-19-тэй тэмцэх

- G20 дээд хэмжээний уулзалтын үеэр COVID-19 хамтарсан тунхаглал зарласан
- БНСУ-ын туршлага болон хөгжиж буй орны эрэлтийг уялдуулан хөгжлийн хамтын ажиллагааг бий болгох
- Олон улсад тархсан халдварт өвчинтэй тэмцэх хамтран ажиллах тогтолцоог бий болгох
- Халдварт өвчингүй болсон дараах үед зориулан ЭМ-ийн салбарынхны чадавхыг бэхжүүлэх

□ ABC хөтөлбөрийн стратеги

[Хөтөлбөр бүрээр] Зорилтот улсад тусламж үзүүлэх, чадавхыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх нийт 3 хөтөлбөрөөс бүрдэнэ

[Он бүрээр] Богино хугацааны(2020-2021он), дунд хугацааны(2022-2024он) гэж ангилна.

- Төслийн багц дээр суурилан 2020 онд шууд хэрэгжих боломжтой төлөвлөгөө боловсруулах

Agenda for Building Resilience against COVID19 through development cooperation	
УРИА	Save Lives, Safe Livelihood

<p style="text-align: center;">ЗОРИЛТ</p>	<ul style="list-style-type: none"> • G20 дээд хэмжээний уулзалтын үеэр COVID-19 хамтарсан тунхаглал зарласан • БНСУ-ын туршлага болон хөгжиж буй орны эрэлтийг уялдуулан хөгжлийн хамтын ажиллагааг бий болгох • Олон улсад тархсан халдварт өвчинтэй тэмцэх хамтран ажиллах тогтолцоог бий болгох • Халдварт өвчингүй болсон дараах үед зориулан ЭМ-ийн салбарынхны чадавхыг бэхжүүлэх 	
<p style="text-align: center;">ҮНДСЭН САНАА</p>	<p style="text-align: center;">STOP зарчим</p> <p>Solidarity (Нийгмийн болон олон улсын эв нэгдэл) Trust (Нийгмийн итгэлцэл) Ownership (Өөриймсөг хандах хандлага) Partnership (Түншлэл)</p>	<p style="text-align: center;">STOP үйлдэл</p> <p>Speed (Түргэн шийдвэр гаргах, түргэн үйлдэл хийх) Transparency (Ил тод бодлого, засаглал) Openness (Мэдээллийн хөгжүүлэлт) Participation (Оролцохыг уриалах)</p>
<p style="text-align: center;">ХӨТӨЛБӨРИЙН НЭР</p>	<p style="text-align: center;">Response (2020-2021)</p>	<p style="text-align: center;">Resilience (2022-2024)</p>
<p>Зорилтот улс орнуудын Эрүүл мэндийн салбарт дэмжлэг үзүүлэх (Action to Fragility)</p>	<ul style="list-style-type: none"> - Оношлуураар хангах - Эм, вакцин гарган авах - Зорилтот бүлэгт хүмүүнлэгийн тусламж үзүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Оношлох технологийн чадавхыг нэгтгэх - Эм болон вакцинаар хангах - Зорилтот бүлгийн нөхөн сэргэх чадавхыг бэхжүүлэх
<p>Хөгжиж буй орнуудын халдварт өвчний менежментийн чадавхыг бэхжүүлэх (Building Capacity)</p>	<ul style="list-style-type: none"> - Халдварт өвчнөөс сэргийлэх сургалт зохион байгуулах - Халдварт өвчнийг урьдчилан шинжлэх чадавхыг бэхжүүлэх - Халдварт өвчинд түргэн арга хэмжээ авах суурийг бий болгох 	<ul style="list-style-type: none"> - Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төслийг бүрдүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх - Халдварт өвчнөөс урьдчилан шинжлэх төслийг бүрдүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх - Халдварт өвчинд арга хэмжээ авах төслийг бүрдүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх
<p>БНСУ-ын туршлагыг ашиглан олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх (Comprehensive Cooperation)</p>	<ul style="list-style-type: none"> - Дотоодын халдварт өвчинд авах арга хэмжээний туршлага судлах - COVID-19-тэй тэмцэх олон улсын иргэний хамтын ажиллагааг сайжруулах - Дотоодын дэдшилтэт технологийг илрүүлэх, тэлэх 	<ul style="list-style-type: none"> - Нийлмэл шинжтэй халдварт өвчний судалгаа шинжилгээг сайжруулах - Олон улсын иргэний хамтын ажиллагааг идэвхжүүлэх - Дотоодын дэвшилтэт технологийг ашиглан хөгжиж буй орнуудыг дэмжих

2. Нарийвчилсан хөтөлбөр

1 Зорилтот улс орнуудын Эрүүл мэндийн салбарт дэмжлэг үзүүлэх (Action to Fragility)

□ Оношлуураар хангах болон Оношлох технологийн чадавхыг нэгтгэх

- (Дотоодын оношлуураар хангах) 4-р сарын байдлаар нийт 37 улсаас дотоодын оношлуурын хүсэлт ихээр ирж байна.
 - ГХЯ-аас хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд оношлуур болон эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах талаар хэлэлцэж байна.
- Хөгжиж буй улсуудын халдварт өвчин оношлох чадавхыг бэхжүү;эх
 - Оношлуураар хангаад зогсохгүй халдварт өвчнийг оношлох технологийг тус улсын дотоодын нөөцийг ашиглан бий болгох

□ Эм, вакцин гарган авах болон вакцинаар хангах

- COVID-19-ийг эмчлэх эм болон вакцин гарган авахад дэмжлэг үзүүлэх
 - Олон улсын эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран эм, вакцин гарган авах (CEPI, GAVI, Global Fund, Unitaid, WHO гэх мэт)
- COVID-19-ийг эмчлэх эм болон вакцинаар хангахад дэмжлэг үзүүлэх
 - Шинээр гарган авсан эм болон вакциныг олон улсын эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран хөгжиж буй улсуудад олгох.

□ Зорилтот бүлэгт хүмүүнлэгийн тусламж үзүүлэх болон нөхөн сэргэх чадавхыг бэхжүүлэх

- Зөвхөн эрүүл мэндийн тусламж үзүүлэх биш хүнс, аюулгүй байдал, боловсрол гэх мэт бүх талаас нь дэмжлэг үзүүлэн тухайн улсын сэргэн нөхөх байдлыг сайжруулах
 - ▲ КОИСА-гийн сургалтанд хамрагдагч, ▲ Иргэний нийгэм, ▲ Хувийн хэвшил, ▲ Төрийн байгууллага зэрэг КОИСА-гийн үйл ажиллагаатай уялдуулан тусламж үзүүлэх.
 - Хөгжиж буй улсын хүүхдийн боловсролыг дэмжих үүднээс онлайн сургалт оруулах мөн хэвийн амидрах нөхцөл байдлыг бүрдүүлж өгөх(цэвэр усаар хангах, энх тайван байлгах, нөхөн сэргээх гм)
- COVID-19-өөс болж нэн хэцүү байдалтай байгаа Сири улс болон Рохингяа үндэстэн гэх мэт хүмүүст түлхүү дэмжлэг үзүүлэх
- COVID-19-өөс болж эдийн засгийн хямралд орсон, үйлдвэрлэл зогссон, ажилгүйдлийн байдал ихэссэн гэх мэт удаан үргэлжлэх төлөвтэй байдалд хариу арга хэмжээ авах

- Зорилтот бүлгийн хүмүүст зориулан нийгмийн аюулгүй байдлыг бий болгох мөн хувийн жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих.

② Хөгжиж буй орнуудын халдварт өвчний менежментийн чадавхыг бэхжүүлэх(Building Capacity)

□ Урьдчилан сэргийлэх(Prevention)

- Нутгийн иргэдэд зориулан онлайн мэдлэг өгөх, эрүүл мэндийн аян өрнүүлэх.
 - Хөгжиж буй улсын иргэдийг халдварт өвчнөөс сэргийлэх үүднээс ▲ анхан шатны эрүүл мэндийн мэдлэг олгох(гар угаах, маск зүүх гм), ▲ нийгмийн харилцаанд зай барих(Social distancing), ▲ сэжигтэй тохиолдол илэрсэн тохиолдолд арга хэмжээ авах гэх мэт сэдвээр богино хэмжээний бичлэг хийж тараах.
- Халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх дунд болон урт хугацааны төсөл хөтөлбөр боловсруулах болон хэрэгжүүлэх
 - Хөгжиж буй улсын халдварт өвчинтэй тэмцэх бодлогын чадавхыг бэхжүүлэх төсөл боловсруулах

□ Эрт илрүүлэх(Early Detection)

- Untact хэлбэрийн эрүүл мэндийн ажилтны чадавхыг бэхжүүлэх(VR зохион бүтээх гм)
 - Оношлуур хүлээн авагч улсуудын эрүүл мэндийн салбарын ажилтнуудад зориулж шинжилгээний дарааллыг бичсэн зааварчилгаа, мэргэжлийн тенникийн сургалтын бичлэгийг боловсруулах болон түгээх.
- (Техникийн зөвөлгөө өгөх) Мэргэжилтнүүдийн онлайн хурал болон онлайн үйлчилгээгээр хангах зэрэг техникийн зөвөлгөөг уялдуулах
 - Оношлох техникийг түгээхийн тулд онлайн сургалтын материал боловсруулах болон түгээх
- Дунд болон урт хугацааны халдварт өвчинг судлах төслийг боловсруулах болон хэрэгжүүлэх
 - Халдварт өвчинтэй тэмцэх хүний нөөцөд зориулсан сургалтыг бий болгох, судалгааны лабораторын тогтолцоог шинэчлэх болон халдварт өвчнийг судлах тогтолцоог бий болгох төслийг боловсруулах

□ Түргэн хариу арга хэмжээ авах(Response)

- COVID-19-ийн эрсэг хариу арга хэмжээ авах онлайнд суурилсан FAQ-г боловсруулах
 - Хөгжиж буй улс · дотоодын халдварт өвчний мэргэжилтнүүд хоорондын мобайл асуулт хариултын платформ үүсгэх.
 - Хөгжиж буй улсын төрийн албан хаагчид болон эрүүл мэндийн салбарын ажилтнуудын асуулт хариултын эрэлтэд суурилсан FAQ бичлэг хийж түгээснээр хоорондын холбогдох сувгийг үүсгэх.
- Бүсийн нийгэмд суурилсан халдварт өвчинтэй тэмцэх чадварыг бэхжүүлэх
 - Иргэдэд тохирсон хариу арга хэмжээ авах, амь нас, аюулгүй байдлад тулгамдсан халдварт өвчний улмаас учрах сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх
- Дунд болон урт хугацааны халдварт өвчинтэй тэмцэх хөтөлбөр боловсруулах болон хэрэгжүүлэх
 - Хөгжиж буй оронд салбар бүрээс хамтран шуурхай арга хэмжээ авах, тулгамдах асуудалд дэмжлэг үзүүлэх төслийг судлах

3 БНСУ-ын туршлагыг ашиглан олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх (Comprehensive Cooperation)

- **Дотоодын туршлагыг хуваалцах болон нийлмэл шинжтэй халдварт өвчний судалгаа шинжилгээг сайжруулах**
- COVID-19-ийн эсрэг хариу арга хэмжээ авах БНСУ-ын туршлагыг 5 сэдэвт хуваан судлаж, түгээх
 - ΔБНСУ-ын халдварт өвчинтэй тэмцэх тогтолцоо, ΔАрдчилсан засаг захиргаа, ΔЭМ-ийн бодлого болон тогтолцоо, ΔЭМ-ийн харилцаа болон хямралын менежмент, ΔICT-д суурилсан халдварт өвчний удирдлага.
- БНСУ-ын туршлагыг ашигласан нийлмэл шинжтэй халдварт өвчний судалгаа шинжилгээг сайжруулах
 - Халдварт өвчин хариуцсан алба, Улсын төв эмнэлэг, Анагаах ухааны их сургуультай хамтарсан Хөгжиж буй буй улсын халдварт өвчний судалгааны чадавхыг бэхжүүлэх болон хяналтын тогтолцоог бий болгох.
 - Сайжруулсан ICT орчин болон ардчилсан, шилэн мэдээллийг нээх, иргэдийн идэвхтэй оролцоонд суурилсан хөгжиж буй улсын халдварт өвчинтэй тэмцэх тогтолцоог сайжруулах.

□ COVID-19-тэй тэмцэх олон улсын иргэний хамтын ажиллагааг сайжруулах болон платформыг идэвхжүүлэх

- Олон улсын иргэний сургалтыг идэвхжүүлэх болон К-МООС онлайн орчны хүрээг тэлэх

- Үзэн ядах, ялгаварлан гадварлах асуудлыг шийдэх, цаг уурын өөрчлөлт болон халдварт өвчний тархалт зэрэг асуудлуудыг шийдвэрлэхийн тулд олон улсын иргэний сургалтын хүрээг тэлэх мөн онлайн сургалтыг хэрэгжүүлэх.

- Түр нутаг буцсан сайн дурын ажилтнуудыг олон улсын иргэний сургалтын багшаар бэлтгэх, контент хөгжүүлэх болон буцаж тухайн улсад томилогдсоны дараагаар сургалт болон аян хэрэгжүүлэх

- Глобал иргэний нийгэмтэй хамтран ажиллах

- COVID-19 дэлхий нийтэд тархсантай холбоотой түүний үр нөлөө болон хариу арга хэмжээний талаарх дүгнэлтээр дамжуулан улс бүрийн иргэний нийгэмтэй уялдуулах, хамтарсан хэлэлцүүлэг болон COVID-19 халдварт өвчний дараах нөхцөл байдал дээр олон улсын хөгжлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.

- БНСУ-ын хариу арга хэмжээ авсан туршлагатай холбоотой судалгаа хийх болон туршлага хуваалцахын тулд хөгжиж буй орны ИНБ-ын зөвлөлтэй хамтран ажиллах мөн сэтгэлзүйн эмчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

□ Дотоодын дэвшилтэт технологийг илрүүлэх, тэлэх мөн түүгээр дамжуулан хөгжиж буй орнуудыг дэмжих

- Халдварт өвчинтэй тэмцэх дотоод гадаадын дэвшилтэт технологийг хөгжүүлэх болон дэлгэрүүлэх

- Халдварт өвчинтэй тэмцэх дотоод гадаадын дэвшилтэт технологийг хөгжүүлэх, шилдэг санаа дэвшүүлэх, нийгмийн үйлдвэрийг идэвхжүүлэх болон экосистемийг дэмжих.

- COVID-19-ийн эсрэг дэвшилтэт технологитой дотоодын компани болон гадаадын хөрөнгө оруулагчдыг холбож өгөх.

III. Жил бүрийн ажил хэрэгжилтийн нарийвчилсан чиглэл

I. [Богино хугацааны] 2020 онд авах шуурхай арга хэмжээний төлөвлөгөө

- Plan A: Нөхцөл байдал 7-р сард хэвийн болох тохиолдолд

■ (Нэмэлт төсөв шаардагдах хөтөлбөр) Хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрийн нийт үл хэрэглэх төсөв санхүүг ABC хөтөлбөрүүдээс хамгийн яаралтай бөгөөд нэн даруй хэрэгжүүлэх боломжтой хөтөлбөрт зарцуулах)

*COVID-19-ийн оношлуураар яаралтай хангах тухайд, Гадаад харилцааны яамнаас мөрдөж буй зарчмын дагуу Гадаад харилцааны яамны хүмүүнлэгийн тусламжийн зорилгоор ашиглах мөнгөн тусламжаар санхүүжүүлэлтийг шийдэх бөгөөд төсөв хоорондын зохицуулалт хийж шилжүүлнэ.

① COVID-19 халдвартай өргөн хүрээнд тэмцэх яаралтай тусламжийн хөтөлбөр (шинэ):

○ (Хэрэгжүүлэлтийн чиглэл) KOICA-гийн Төлөөлөгчийн газар байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж буй 44 улсаас гадна зорилтот улс бүрт боломжит төсвийн хүрээнд мөнгөн тусламжийг тогтоох ба суурин төлөөлөгчийн газар болон дипломат төлөөлөгчийн газрын хэлэлцээн дээр тулгуурлан COVID-19 халдвартай тэмцэх яаралтай тусламжийн хөтөлбөрийг шуурхай төлөвлөж тухайн улсын нөхцөлд нийцүүлэн уян хатан байдлаар хэрэгжүүлэх.

○ (Гол бүтэц) Төсвийн хязгаарт багтаан зорилтот улсын хэрэгцээг үндэслэн хуваарилах.

- (Хүмүүнлэгийн тусламж) COVID-19 халдварын эсрэг арга хэмжээ авах модульчлогдсон түр эмнэлгийн байгууламж (эмнэлгийн бүрэн тусгаарлах өрөө багтсан), эмнэлгийн хангамж, тоног төхөөрөмж зэргээр дэмжлэг үзүүлэх.
- (Халдварт өвчний эсрэг арга хэмжээ) COVID-19 халдварын эсрэг арга хэмжээ авах мэргэжлийн боловсон хүчин (лабораторийн үзлэгийн ажилтан, тандалт судалгааны ажилтан, халдварт өвчний эсрэг бодлогын мэргэжилтэн, эрүүл мэндийн мэргэжилтэн гэх мэт)-д зөвлөгөө өгөх, ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, оношлуураас гадна хамгаалалтын хэрэгсэл болон walk-through, аюулгүй ажиллагааны хэрэгслээр хангах зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх Хөгжлийн албан ёсны тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
- (Хөдөө аж ахуйн салбар) Хүнсний яаралтай тусламж, орлогыг нэмэгдүүлэх хөтөлбөрийг бэхжүүлэх, тогтвортой дэмжлэг үзүүлэх.
- (Боловсролын салбар) Сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр болон хөл хорионы дэглэмээс шалтгаалсан хоол тэжээлийн дутагдалд орохоос сэргийлэх. (Яаралтай тусламжийн хоол хүнсээр хангах), цахим сургалт болон tablet pc-г ашиглан сургалт зохион байгуулах талаарх сургалт гэх мэт.
- (Зорилтот бүлэг) Дүрвэгсэд, үндэстний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт эмзэг бүлгүүдэд зориулсан тусгай дэмжлэг (дүрвэгсдийн лагерь GBV урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн зайлшгүй шаардлагатай хэрэгслээр хангах, орлогыг нэмэгдүүлэх хөтөлбөрийг бэхжүүлэх, тогтвортой дэмжлэг үзүүлэх).
- (Иргэний нийгэм) Засгийн газрын бодлогын шийдвэр гаргах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, олон нийтэд төвлөрсөн аюултай тэмцэх чадварыг нэмэгдүүлэх (нэгдэл, харилцаа холбоо), мэдээлэлжих зорилгоор сүлжээг бэхжүүлэх.

- (Хувийн хэвшил) Ажил эрхлэлтийг хадгалах, орлогын эх үүсвэрийг бүтээх зорилготой жижиг бизнес эрхлэгчийг дэмжих (бичил зээлийн шууд бус санхүүжилт, баталгаа), БНСУ болон хөгжиж буй орон хоорондын хувийн хэвшлийн салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх.

② Улаан загалмайн нийгэмлэг болон иргэний нийгмийн хамтарсан хүмүүнлэгийн тусламж:

○ (Төрөл) БНСУ-ын иргэний нийгмийн байгууллагатай хамтарч хүмүүнлэгийн тусламж үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөр

○ (Зорилго) Шилжин ирэгсэд, дүрвэгсэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг зорилтот бүлгийг дэмжих

○ (Хамтран ажиллах байгууллага) БНСУ-ын Улаан загалмай нийгэмлэг болон БНСУ-ын ТББ

▶ (Арга) КОИСА болон БНСУ-ын Улаан загалмай нийгэмлэг хооронд Харилцан ойлголцлын санамж бичиг (MOU) байгуулж хөтөлбөрийн үйл ажиллагааг даалгах

- БНСУ-ын Улаан загалмайн нийгэмлэг болон тусламж хүлээн авагч улсын Улаан загалмайн нийгэмлэгийн хамтын ажиллагаат хөтөлбөр

▶ (Агуулга) ΔХөгжиж буй орны зорилтот бүлгийн иргэдэд эрүүл ахуйн мэдлэг олгох, олон нийтийн эрүүл ахуйн ойлголтыг сайжруулах, Δэрүүл ахуй, өдөр тутмын хэрэгцээт барааны дэмжлэг үзүүлэх, Δсэтгэлзүйн эмчилгээ, амьжиргааны дэмжлэг

▶ (Төсөв)

- БНСУ-ын Улаан загалмайн нийгэмлэг болон тусламж хүлээн авагч улсын Улаан загалмайн нийгэмлэгийн хамтын ажиллагаат хөтөлбөр:
- БНСУ-ын Улаан загалмайн нийгэмлэг болон КСОС-ын хүмүүнлэгийн тусламж үзүүлэх Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөр:

③ Хөгжиж буй орны социал энтерпрайз-д үзүүлэх яаралтай тусламж

○ (Төрөл) Шилдэг түнш бэлтгэх, загвар бизнес (нийгмийн эдийн засгийн инкубацийн хөтөлбөрийг ашиглах)

○ (Зорилго) COVID-19 халдварын улмаас хумигдсан түнш орны эдийн засгийг сэргээх, нийгмийн энтерпрайзуудын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагаатай уялдуулан нийгмийн хувь нэмрийг нэмэгдүүлэх

○ (Хамрах хүрээ) Түнш орнуудын 150 социал энтерпрайз

► (Арга) KOICA – Нийгмийн Үнэ цэнийн Нэгдсэн Сан – БНСУ-ын Шударга Худалдааны Зөвлөл – GSEF (Global Social Economy Forum) 4 талын Харилцан ойлголцлын санамж бичиг (MOU) байгуулна.

► (Агуулга) Нийт 150 социал энтерпрайзуудад 10,000 аас 15,000 ам долларын хооронд үйл ажиллагааны хөрөнгийн яаралтай тусламжийг үзүүлснээр социал энтерпрайзуудын тогтвортой байдлыг хангаж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд хэрэглэгдэх хэрэгслийн үйлдвэрлэлийг идэвхжүүлнэ.

► (Төсөв)

*(Урьд нь байсан төсвийн хүрээнд санхүүжүүлнэ) Бусад 2020оны богино хугацааны хөтөлбөрүүдийг салбар болон улс тус бүрийн төсвийг ашиглаж хэрэгжүүлнэ.

○ (Хамтын ажиллагааны төсөл) COVID-19 халдвартай тэмцэх хамтын ажиллагааны төсөл

- (Эд материалаар дэмжих) Оношлуур, эмнэлгийн тоног төхөөрөмж, эмийн бүтээгдэхүүн гэх мэт
- (Халдварт өвчний эсрэг хариу арга хэмжээ авах · эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх) Холбогдох дэд бүтэц, эмнэлгийн хог хаягдлын менежмент, эрүүл мэндийн ажилчдын цалин, surveillance тандалтын мэдээллийн системээр тусламж үзүүлэх. Бусад халдварт өвчин (хумхаа, сүрьеэ гэх мэт)-ий эсрэг арга хэмжээ авах хөтөлбөртэй холбон хөтөлбөрийн хамрах хүрээг тэлэх, эмнэлгийн болон хяналтын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан сургалтанд COVID-19 халдвартай тэмцэх сургалтыг багтаах, эх хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөрийн сургалтанд COVID-19 халдварын эсрэг хариу арга хэмжээ авах сургалтыг багтаах.
- (Эрүүл ахуйн салбар) WASH төсөлтэй уялдуулан эрүүл ахуйн боловсрол олгох. Мөн саван гэх мэт гар халдваргүйжүүлэх хэрэгсэл, хэрэгцээт эд материалаар хангах
- (Иргэний нийгэм) Аюулын менежментийг сайжруулах, харилцаа холбоог бэхжүүлэх дэмжлэг (радио/SNS мессенжер ашиглах, олон нийтийн зөвлөл болон шашны удирдагчдын сүлжээ)
- (Инноваци технологи) Хөгжиж буй орнуудтай хамтран халдварт өвчний оношлогооны технологийг боловсруулж, хамтарсан үйлдвэрлэлийн дэмжлэг үзүүлэх.

○ (Глобал хөтөлбөр) Өмнөх хөтөлбөрийн аргачлалыг өөрчлөх, шинэлэг технологийг ашиглах гэх мэт түншлэлд суурилсан COVID-19 халдварын эсрэг шуурхай арга хэмжээ авах дэмжлэг

- (Глобал боловсон хүчин) Глобал боловсон хүчин E-volunteering, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх аян
- (Сургалт) KOICA-гийн сургалтанд хамрагдсан албан хаагчтай холбоотой яаралтай тусламж, COVID-19 халдварын зайн оношилгооны чадавхыг бэхжүүлэх

- (Инноваци) Шинэлэг технологийг ашиглан боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх. Дотоод гадаадын инновацилаг технологийг илрүүлж дэлгэрүүлэх

○ (Хөгжлийн хамтын ажиллагаа болон хүмүүнлэгийн тусламж) Иргэний нийгмийн хамтын ажиллагаанд суурилж тухайн улсын нийгмийг дэмжих

- (Иргэн) Бүс нутгийн шуурхай арга хэмжээ, халдварт өвчинтэй тэмцэх чадварыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт · ойлголтыг сайжруулах, хөгжиж буй улс орны нийгмийн энтерпрайзийг дэмжих
- (Хүмүүнлэг) Улаан загалмайн нийгэмлэг · иргэний нийгэм хамтын ажиллагаан дээр суурилсан яаралтай тусламж

○ (Хамтын ажиллагааны төслийн дэмжлэг) Судалгаа болон Хөгжлийн албан ёсны тусламж (ODA)-ийн сургалт зэрэг COVID-19 халдвартай тэмцэх зорилготой төсөл хөтөлбөрийг нэмэгдүүлэх

- (Судалгаа) БНСУ-ын хэрэгжүүлсэн COVID-19 цар тахлын эсрэг арга хэмжээг судлах, цахим зөвлөгөө
- (ODA сургалт) Дэлхийн иргэний боловсрол дээр суурилсан олон улсын эв нэгдлийг бэхжүүлэх

○ (Global Disease Eradication Fund) Олон улсын байгууллагуудын COVID-19 халдвартай тэмцэх хамтын ажиллагааг дэмжих

- (Сан) CEPI, GAVI, Global Fund, Unitaid, WHO дэмжих
-

□ **Plan B : Нөхцөл байдал 9-р сард хэвийн болох тохиолдолд**

■ (Plan A +∞) Plan A дээр ▲ COVID-19 халдвартай өргөн хүрээнд тэмцэх яаралтай тусламж болон ▲ иргэний нийгмийн хамтын ажиллагааны сонгон шалгаруулалтыг нэмэлтээр нэмнэ.

<Нэмэлт зүйл>

1. COVID-19 халдвартай тэмцэх яаралтай тусламж (KOICA-гийн төсөв) : (Plan A +)
2. Бүсийн нийгэмд суурилсан COVID-19 халдварын эсрэг шуурхай арга хэмжээний нэмэлт сонгон шалгаруулалт : (Plan A +)

<Өмнөхтэй ижил зүйл>

3. Улаан загалмайн нийгэмлэг болон иргэний нийгмийн хамтын ажиллагаан дээр суурилсан хүмүүнлэгийн тусламж (Plan A-тай ижил)
4. Хөгжиж буй орнуудын социал энтерпрайз-д яаралтай тусламж үзүүлэх (Plan A-тай ижил)

*(Урьд нь байсан төсвийн хүрээнд санхүүжүүлнэ) Plan A-тай ижил

□ **Plan C : Нөхцөл байдал энэ жил хэвийн болох боломжгүй тохиолдолд**

■ (Plan B +∞) Plan B дээр ▲ COVID-19 халдвартай өргөн хүрээнд тэмцэх яаралтай тусламжийг огцом нэмэгдүүлэх

<Нэмэлт зүйл>

1. COVID-19 халдвартай тэмцэх яаралтай тусламж (KOICA-гийн төсөв) : (Plan B +)

<Өмнөхтэй ижил зүйл>

2. Бүсийн нийгэмд суурилсан COVID-19 халдварын эсрэг шуурхай арга хэмжээний нэмэлт сонгон шалгаруулалт : (Plan B-тэй ижил)
3. Улаан загалмайн нийгэмлэг болон иргэний нийгмийн хамтын ажиллагаан дээр суурилсан хүмүүнлэгийн тусламж: (Plan B-тэй ижил)
4. Хөгжиж буй орнуудын социал энтерпрайз-д яаралтай тусламж үзүүлэх (Plan B-тэй ижил)

*(Урьд нь байсан төсвийн хүрээнд санхүүжүүлнэ) Plan B-тэй ижил

Хавсралт 2: 2020оны ABC шуурхай арга хэмжээний хөтөлбөрийн үндсэн агуулга

[1] [Хамтын ажиллагааны төсөл] COVID-19 халдвартай тэмцэх арга хэмжээг хамтын ажиллагааны төсөлтэй уялдуулах

□ Төслийн ерөнхий мэдээлэл

- **(Төслийн нэр)** COVID-19 халдвартай тэмцэх арга хэмжээг хамтын ажиллагааны төсөлтэй уялдуулах
- **(Хэлбэр)** Төсөл
- **(Зорилго)** Хөгжиж буй орнуудад COVID-19 халдварын эсрэг шуурхай арга хэмжээ авах
- **(Хамрах хүрээ)** КОЙКА-гийн суурин төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явагдаж буй улс орнууд болон зарим нэмэлт улс орнуудад хэрэгжүүлж буй шинэ, үргэлжлэх, дууссан төсөл - ▲ халдварт өвчний эсрэг арга хэмжээ авахтай холбоотой болон эрүүл мэндийн салбарын төсөл хөтөлбөрийн зохицуулалтаар дамжуулан дэмжлэг үзүүлэх, ▲ амьжиргааны баталгаа, боловсрол, хүний эрх, хүүхэд, эмэгтэйчүүдтэй холбоотой асуудлуудын хүрээнд хэрэгжүүлж буй төсөлтэй уялдуулан дэмжлэг үзүүлэх
- **(Хугацаа)** Богино хугацааны: 2020-2021, дунд болон урт хугацааны: 2022-2024

□ Дэлгэрэнгүй агуулга

- **(Чиглэл)** ▲ халдварт өвчний эсрэг арга хэмжээ авахтай холбоотой болон эрүүл мэндийн салбарын төсөл хөтөлбөрийн зохицуулалтаар дамжуулан дэмжлэг үзүүлэх, ▲ амьжиргааны баталгаа, боловсрол, хүний эрх, хүүхэд, эмэгтэйчүүдтэй холбоотой асуудлуудын хүрээнд хэрэгжүүлж буй төсөлтэй уялдуулан дэмжлэг үзүүлэх, ▲ төслийн төлөвлөгөөний хүрээнд зарим үйл ажиллагааг өөрчилж COVID-19 халдварын эсрэг шуурхай арга хэмжээ зохион байгуулах

○ (Төслийн төрөл) Төрөл тус бүрт тохирсон төлөвлөгөө

Төрөл	1. Глобал эрүүл мэнд, аюулгүй байдлын төсөл	2. Халдварт өвчин(сүрьеэ гэх мэт) болон эрүүл мэндтэй холбоотой төсөл	3. Бусад хамтын ажиллагааны төсөл
Арга хэмжээ	Тухайн жилийн төслийн агуулга эсвэл төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж COVID-19 халдварын эсрэг шуурхай арга хэмжээ авах	Одоо байгаа дэд бүтцийг ашиглан COVID-19 халдварын эсрэг шуурхай арга хэмжээ авах үйл ажиллагааг нэмэгдүүлэх, төслийн дараах дэмжлэгт зориулагдсан төсвөөс санхүүжүүлэх	Газар тариалангийн хөгжил, боловсрол, зорилтот бүлэгт дэмжлэг үзүүлэх гэх мэт олон төрлийн төслийн хүрээнд өргөн хүрээнд нөхөн сэргэлтийг дэмжих
Жишээ	▲ Оношлуур, төхөөрөмж яаралтай худалдан авах ▲ шуурхай арга хэмжээ авах системийг бүрдүүлэх ▲ Мэргэжилтний зөвлөгөө	▲ Өмнөх төслөөр баригдсан эмнэлгийг COVID-19 халдвартай тэмцэхэд ашиглах ▲ Эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан сургалтанд COVID-19 халдварын эсрэг арга хэмжээ авах сургалтыг багтаах	▲ Хүнсний яаралтай тусламж, орлогын тусламж ▲ Боловсролын яаралтай тусламж ▲ Зорилтот бүлгийг дэмжих тусгай хөтөлбөр

○ (Үйл ажиллагаа)

- (Шуурхай арга хэмжээнд шаардлагатай эд материалын дэмжлэг) ▲ Оношлуур (хүмүүнлэгийн дэмжлэгтэй давхцахгүй байх, үргэлжилж байгаа төслийн төсвөөс санхүүжүүлэх.) ▲ Эмнэлгийн тоног төхөөрөмж, эмийн бүтээгдэхүүн (Дотоодоос хангаж чадахгүй тохиолдолд UNOPS болон олон улсын байгууллагуудаар дамжуулж тухайн улсаас худалдан авах боломжийг бодолцоно.)
- (Мэргэжилтний зөвлөгөө) Мэргэжилтнийг томилох боломжгүй тохиолдолд цахим болон бичлэгийг ашиглан мэргэжлийн багаас бодлого, ур чадвар, техникийн зөвлөгөө олгох. Мэргэжилтнийг томилох боломжтой тохиолдолд томилох. (Дотоод/гадаадын мэргэжилтнүүдийн сүлжээг ашиглах)
- (Халдварт өвчний эсрэг арга хэмжээ · эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх) ▲ Холбогдох дэд бүтэц, эмнэлгийн хог хаягдлын менежмент, эрүүл мэндийн ажилчдын цалин, surveillance тандалтын мэдээллийн системийн тусламж үзүүлэх. Бусад халдварт өвчин (хумхаа, сүрьеэ гэх мэт)-ий эсрэг арга хэмжээ авах хөтөлбөртэй холбон хөтөлбөрийн хамрах хүрээг тэлэх, эмнэлгийн болон хяналтын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх дэд бүтцийг ашиглах, эрүүл мэндийн ажилчдын сургалтад COVID-19-ийн эсрэг хариу арга хэмжээ авах сургалтыг багтаах, эх

хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөрийн сургалтанд COVID-19-ийн эсрэг хариу арга хэмжээ авах сургалтыг багтаах.

- (Ариун цэврийн салбар) WASH төсөлтэй уялдуулан ариун цэврийн боловсрол олгох. Мөн гар халдваргүйжүүлэх хэрэгсэл, саван гэх мэт хэрэгцээт эд материалаар хангах.
- (Ойлголтыг сайжруулах) Олон нийтийн эрүүл мэндийн идэвхтэн (community health worker)-ийн сүлжээгээр дамжуулж аюулын менежмент болон харилцаа холбоог сайжруулах. (радио/SNS мессенжер ашиглах, олон нийтийн зөвлөл болон шашны удирдагчдын сүлжээг ашиглах)

□ Төсөв

○ (Төсвийн шатлал) Бүс нутаг бүрээр үзүүлж буй буцалтгүй тусламж, төслийн үр нөлөөг нэмэгдүүлэх зардал – төслийн дараах дэмжлэг, зорилтот улс оронд үзүүлэх тусламж

○ (Төсвийн дүн) тооцож байгаа.

- 1,650,000 ам доллар бүхий шинэ болон үргэлжилж буй төслийн төсөв (үндсэн төсвийн хүрээнд санхүүжүүлэх)
- 2,300,000 ам доллар бүхий төслийн дараах дэмжлэг үзүүлэх төслийг санхүүжүүлэх (үндсэн төсөв болон нэмэлт)
- + ∞ төслийн төлөвлөгөөг өөрчлөх (төсвийн дүнг нэмэгдүүлэх, хугацааг сунгах) замаар нэмэлт дэмжлэг үзүүлэх
- Дээр дурдсан төлөвлөгөөний дагуу дэмжлэг үзүүлэх боломжгүй улс оронд зорилтот улс оронд үзүүлэх дэмжлэгийн хүрээнд хэрэгжүүлэх шинэ төслийн төсвөөр (4.1 тэрбум ам доллар) санхүүжүүлнэ.

□ Жишээ

< (Жишээ) Эрүүл мэндийн салбарт хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх >

- Камбож улсад Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээний тогтолцоог сайжруулах төсөл (2020-2025/8.5сая ам доллар)
 - 500,000 ам долларыг COVID-19 халдварын эсрэг арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж байна.
- Гана улсад Глобал эрүүл мэндийн аюулгүй байдлын төлөвлөлтийг бэхжүүлэх төсөл (2018-2021/7.5сая ам доллар)
 - Гана улсын эрүүл мэндийн аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй төсөл бөгөөд ▲ лабораторын хүчин чадлыг сайжруулах, ▲ яаралтай арга хэмжээ авах тогтолцоог сайжруулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг тул нэмэлт өөрчлөлтгүйгээр уг төслийн хүрээнд COVID-19 халдвартай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой.

< (Жишээ) Филиппин улсын хамтын ажиллагааны төслийн хүрээнд
хүнсний яаралтай тусламж үзүүлэх >

- (Нөхцөл байдлын анализ) COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор бүс нутагт хөл хорио тогтоосноор хот суурин газрын иргэдийн амьжиргаа муудсан. Мөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг тээвэрлэх арга замын хязгаарлалтаас үүдэлтэй орлого буурах асуудал үүссэн.
- (Тусламж үзүүлэх төлөвлөгөө) КОЙКА-аас хөдөө аж ахуйн салбарт дэмжлэг үзүүлсэн төсөлтэй уялдуулан хот суурин газрын гачигдалтай иргэд болон орон нутгийн гачигдалтай тариачдад дэмжлэг үзүүлэх (200,000 ам долларын өртөг бүхий материаллаг тусламж) - КОЙКА-аас дэмжлэг үзүүлсэн тариачдын нэгдэл + үр тариа боловсруулах байгууламжаар дамжуулан худалдан авах-боловсруулах-савлах-тээвэрлэх

<КОЙКА-гийн Poilo хотод хэрэгжүүлсэн хөдөө аж ахуйн төсөл >

Төслийн нэр	Panay арал дахь хөдөө аж ахуйг хөгжүүлэх төсөл	Үр тариа боловсруулалтын байгууламжийг дэмжих төсөл
Төслийн ерөнхий мэдээлэл	■ 2015-2019он _ 6.5сая ам доллар	■ 2009-2012он _ 13сая ам доллар
Зорилтот бүс	■ Panay арлын 4хот – Poilo, Capiz, Antique, Aklan	■ 4 бүс нутаг – Poilo, Bohol, Pangasinan, Davao
Хэрэгжүүлэлтийн байдал	<ul style="list-style-type: none"> ■ КОЙКА-гийн дэмжлэгтэй Panay төсөл _ тариачдын нэгдлийн өнөөгийн байдал · Сан Мигуэл хөдөө аж ахуйн хамтын нийгэмлэг LTF _ 1бүлэг 100 гишүүн * LTF _ Local Food Terminal _ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа · Тариачдын BTC нэгдэл _ 10 бүлэг 1200 гишүүн *BTC_Bayanihan Tiron Center _ фермийн газар 	<ul style="list-style-type: none"> ■ Poilo Pototan RPC стандарт · Тариаланчдын эвлэл 4000гишүүн, жил бүр 350тонн будаа

<Улс тус бүрийн хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх дэмжлэгийн төлөвлөгөө >

Улс	Хөтөлбөрийн агуулгын хүрээнд COVID-19 халдвартай тэмцэх арга хэмжээг багтаасан төлөвлөгөө	Төсөв санхүү	Нэмэлт төсөв
Камбож	<ul style="list-style-type: none"> ○ Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоог бэхжүүлэх төсөл (2020-2025/8.5сая ам доллар) – 500,000 ам долларыг COVID-19 халдварын эсрэг арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж байна. – Нарийн төлөвлөгөөг тус улсын эрүүл мэндийн яамтай хэлэлцэх болно. 	500,000 ам доллар	-
Филиппин	<ul style="list-style-type: none"> ○ Филиппин UNICEF эхний1000өдрийн шим тэжээлийг сайжруулах төсөл (2018-2021/6сая ам доллар) – үйл ажиллагааны явцад онцгой байдал/гамшиг гарсан тохиолдолд эрүүл мэндийн хариу арга хэмжээ авах, WASH, вакцинаар хангах гэх мэт (200,000~300,000ам долларыг зорилтот газар PPE олгох) –UNICEF-ээр дамжуулж олгох боловч марк наах ○ (Дууссан төсөл) Төслийн дараах дэмжлэгт зориулсан төсвийг ашиглах –Эрүүл мэндийн салбар: Солонгос-Филиппиний хамтарсан Кавите эмнэлэг 1~3дахь удаагийн төсөл, Poilo хотын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах төсөл (150,000ам доллар-р 2удаа) –Яаралтай тусламжийн хүнс: үр тариа боловсруулалтын байгууламжийг дэмжих төсөл болон Papanu хөдөө аж ахуйн нэгдсэн хөгжлийн төсөл (200,000 ам доллар) 	300,000 ам доллар	500,000 ам доллар (эрүүл мэнд 150,000ам доллар-2удаа, яаралтай тусламжийн хүнс 200,000ам доллар)
- **(Төлөвлөгөөг хэрэгжүүлэх)** Цаг үеэ олсон, давхцаж буй эсэх зэргийг судалсны үндсэн дээр хамтрагч байгууллага(тухайн орны ТББ, орон нутгийн засгийн газар зэрэг) болон салбар нэгж(үлдсэн хүн хүч)-ийг ашиглан тухайн улсаас тавьсан хориг, зөвлөмжийг зөрчилгүй үйл ажиллагаагаа явуулах(2020.4.13~)

- **(Үр дүнг шалгах)** Хагас улирал бүрээр төслийн хэрэгжилтийн байдлаар Covid-19-тэй тэмцэх ажлын бүтээмж, үр дүнг хянаж, нэгдсэн удирдлагаар хангах

□ **Шаардлагатай төсөв**

○ **(Төсвийн нэр)** Хөгжлийн хамтын ажиллагаа болон хүмүүнлэгийн тусламж(ЗГ-ын санхүүжилт)-Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны төсөл(ODA)-Сэдэв бүрээр хэрэгжүүлэх хөтөлбөр

○ **(Шаардлагатай төсөв)** 380сая вон

- Өөрийн төсвөөр хэрэгжүүлэх боломжтой

[Б төлөвлөгөө нэмэлт] [Иргэний нийгмийн хамтын ажиллагаа] Бүсийн нийгэмд тулгуурлан Корона19-тэй шуурхай тэмцэх ажиллагаа

□ **Төслийн ерөнхий мэдээлэл**

- **(Төсвийн нэр)** КОЙКА-гаас Covid-19-ийн эсрэг иргэний нийгмийн хамтын ажиллагааны хүрээнд яаралтай дэмжлэг үзүүлэх
- **(Хэлбэр)** Иргэний нийгмийн хамтын ажиллагаа(ТББ-тай хамтран)-ны хүрээнд Covid-19-ийн оношлуураар хангахаас гадна хамтын ажиллагаат улсуудын шуурхай арга хэмжээ
- **(Зорилго)** Оношлуур зэрэг хамтын ажиллагаат улсын хэрэгцээ шаардлагаас гадна иргэний нийгэм(тухайн улсын ТББ, ОУ-ын ТББ-ын холбоо сүлжээг ашиглах)-тэй хамтран боломжтой бусад эрүүл мэндийн болон яаралтай тусламжийн эд материалыг тухайн улсаас худалдан авснаар, бүсийн нийгэм-зорилтот бүлгийг дэмжих ажлыг нэг дор хэрэгжүүлнэ.
- **(Хамрах хүрээ)** КОЙКА-гийн Төлөөлөгчийн газар байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж буй 44 орон, Сир-Лохингяа-гийн дүрвэгдсэд зэрэг
- **(Хэрэгжүүлэх хугацаа)** 2020 оны 6 сар - 12сар

□ **Дэлгэрэнгүй агуулга**

- **(Дэмжлэг үзүүлэх арга)** Тухайн улсын ТББ болон глобал холбоо харилцаатай ОУ-ны ТББ (БНСУ-ын засгийн газар)-тай хамтардаг иргэний нийгмийн хамтын ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- **(Дэмжлэг үзүүлэх агуулга)** Оношлуураас гадна улс тус бүрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тухайн улсаас худалдаж авах боломжтой эмнэлгийн эд материалын дэмжлэг үзүүлэх, амьжиргааг дэмжих ажилтай холбох
- **Ажлын хуваарь, агуулга**
 - (Бүртгэлийн зар явуулах төлөвлөгөө гаргах) Ажил тус бүрийн хүрээг тогтоох, аль нэг улсын хэрэгцээ шаардлагатай холбож бүртгэлийн зар явуулах төлөвлөгөө бэлдэх
 - (Бүртгэх, шалгаруулах) Тухай улсаас худалдан авалт хийх чадвар, сургалт-консолтинг хийхэд мэргэжилтэн байгаа эсэх, тухайн улсын эрүүл мэндийн салбарын бодлого боловсруулах ажилд оролцох боломжтой эсэх асуудлуудад үндэслэн шалгаруулах, тухайн улсын хэрэгцээнд нийцсэн дэмжлэг үзүүлэх системтэй болох

※Сир-Лохингяа зэрэг улс үндэстний дүрвэгсэд үзүүлэх тусламжийг хүмүүнлэгийн тусламж үзүүлэх төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа гэж ангилах(Тусгайлан үзнэ)

- (Улс тус бүрийн хэрэгцээ шаардлагатай холбох, хэрэгжүүлэх) Тухайн улсад байгаа Төлөөлөгчийн газар, сонгогдсон байгууллага хоорондоо хэрэгцээ шаардлагад зохицуулалт хийж, хэрэгжүүлэх арга замыг тогтсоны дараа ажлаа нэг бүрчлэн хэрэгжүүлнэ

- (Үр дүнг шалгах) Нийт бүтээмж, үр дүнг тооцох, боломжтой бол тухайн орны засгийн газар болон дэмжлэг хүлээн авагчийн сэтгэл ханамжийн судалгаа явуулах

□ **Шаардлагатай төсөв**

○ **(Төсвийн нэр)** Хөгжлийн хамтын ажиллагаа болон хүмүүнлэгийн тусламж(ЗГ-ын санхүүжилт)-Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны төсөл(ODA)-Сэдэв бүрээр хэрэгжүүлэх хөтөлбөр

○ **(Шаардлагатай төсөв)** 20 тэрбум вон

- (Нэмэлт төсөв хэрэгтэй) Бусад төслийн төсвөөс татаж хэрэгцээтэй төсвийг бүрдүүлнэ.

[10] [Иргэний нийгмийн хамтын ажиллагаа] Бүсийн нийгэмд тулгуурлан халдварт өвчинтэй тэмцэхэд нөөц бололцоог нэмэгдүүлэх

□ **Төслийн ерөнхий мэдээлэл**

○ **(Төслийн нэр)** Хамтын ажиллагаат улсын бүс нутагт төвтэй халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил болон ундны усны эрүүл ахуйн орчинг сайжруулах

○ **(Төрөл)** Иргэний нийгмийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн эрүүл мэндийн салбарын төсөл, олон улсын өвчинтэй тэмцэх сангийн төр-хувийн хэвшлийн түншлэлийн төсөл

○ **(Зорилго)** Covid-19 болон бусад янз бүрийн өвчний үед эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах

○ **(Хамрах хүрээ)** 17 орон(25 төсөл) анхан шатны эрүүл мэндийн байгууллага-сургууль болон бүсийн нийгэмд дэмжлэг үзүүлэх

○ **(Хэрэгжүүлэх хугацаа)** 2020 он дуустал

□ **Ерөнхий агуулга**

○ **(Дэмжлэг үзүүлэх арга)** 2020 онд хамтын ажиллагаат орнуудын бүсийн нийгэмд төвлөрч, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн байгууллагын тогтолцоог дэмжих төсөл, ундны усны эрүүл ахуйг сайжруулах болон хүчин чадлыг нэмэгдүүлэх төслөөр халдвараас урьдчилан сэргийлэх ажлуудыг хэрэгжүүлэх

○ (Дэмжлэг үзүүлэх агуулга) Эрүүл мэндийн суурь тогтолцоо(орон нутгийн эрүүл мэндийн төвүүд болон анхан шатын эрүүл мэндийн байгууллага)-г чадавхжуулах, халдварт өвчинтэй тэмцэх нөөц бололцоог нэмэгдүүлэх, ундны усны эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх, хүртээмжийг дээшлүүлэх, бие даан ажиллуулах тогтолцоог бий болгох

○ **Ажлын хуваарь, агуулга**

	Хэрэгжилтийн талаар зөвшилцөх, төсөл эхлүүлэх	Халдварт өвчинтэй тэмцэхэд чадавхжуулах	Ундны ус болон эрүүл ахуйн орчинг сайжруулах, удирдах сургалт	Ажлын гүйцэтгэлийг тайлагнах, үр дүнг хянах
агуулга	<ul style="list-style-type: none"> • Хамтын ажиллагаат улсын эрүүл мэндийн бодлоготой холбох, төслийн үр шимийг хүртэгчдийн бүс нутгийн орчин нөхцлийг судлах • Ундны ус, эрүүл ахуйн салбарт эрэмбэлэгдсэн төслүүд болон хүсэлттэй танилцах 	<ul style="list-style-type: none"> • Халдар судлалын байгууллагууд(лаборатори гм), эмнэлэг, бүс нутгийн эрүүл мэндийн тогтолцоонд хамаарал бүхийг хүний нөөцийг чадавхжуулах, дэд бүтцийн дэмжлэг үзүүлэх • Тогтвортой байдлыг хангахын тулд халдварт өвчний удирдлагын тогтолцоог сайжруулах 	<ul style="list-style-type: none"> • Ундны ус эх үүсвэрийг бий болгох, менежментийн хяналт, шалгалт хийх • Ундны усны болон эрүүл ахуйн удирдлагыг чадавхжуулахад чиглэсэн эрүүл мэндийн салбарын хүний нөөц болон бүсийн нийгэмд сургалт-зөвлөгөө өгөх 	<ul style="list-style-type: none"> • Жилийн эхний хагас/жилийн төсөл хэрэгжилтийн гүйцэтгэлийг тайлагнах, шалгах • Корона19-ийн нөхцөл байдалд тулгуурлан уян хатан байдлаар төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, халдварт өвчинтэй тэмцэхэд чиглүүлэх
Хугацаа	1/4 улирал	жилийн турш		2020.7сарын сүүл, 2021.1сарын сүүл

□ **Шаардлагатай төсөв**

○ (Төсвийн нэр) Хөгжлийн хамтын ажиллагаа болон хүмүүнлэгийн тусламж(Засгийн газрын санхүүжилт) - Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл(ODA) - Сэдэв тус бүрээр хэрэгжүүлэх хөтөлбөр/өвчин эмгэгтэй тэмцэх ажил - Төр, хувийн хэвшлийн түншлэлийн олон улсын өвчинтэй тэмцэх(ODA)- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл

○ (Шаардлагатай төсөв) 4 тэрбум 400 сая вон +3 тэрбум(ОУ-ын өвчинтэй тэмцэх сан)
- Өөрийн төсвөөр хэрэгжүүлэх боломтой

[11] [Иргэний нийгмийн хамтын ажиллагаа] Бүсийн нийгэмд халдвараас сэргийлэх сургалт явуулж, ойлголтыг нэмэгдүүлэх

□ **Төслийн ерөнхий мэдээлэл**

- **(Төслийн нэр)** Covid-19-өөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд, эрүүл ахуйн ойлголтыг нэмэгдүүлэх аян
- **(Хэлбэр)** Үндсэн төслүүдийн сургалт, сурталчилгааны ажилд аян өрнүүлэх, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлуудыг нэмж, тусгах
- **(Зорилго)** Халдвараас урьдчилан сэргийлэх, мөрдлөг болгох ажлуудыг таниулан түгээснээр эрсдлийн үед хэрхэн тэмцэх, амь нас аюулгүй байдалтай холбогдсон өвчний тархалтын талаар сандрал аюулыг даван туулахад сэтгэл зүйн хувьд тогтвортой байхад дэмжлэг үзүүлэх
- **(Хамрах хүрээ)** 33 орон(114 төслөөр дамжуулан)-ы иргэний нийгмийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн үр шимийг хүртэгчид
- **(Хэрэгжүүлэх хугацаа)** 2020 оны 4 сараас он дуустал

□ **Ерөнхий агуулга**

- **(Дэмжлэг үзүүлэх арга)** 2020 оны төслүүдийг хэрэгжүүлэх явцад бүх ажлыг халдвараас сэргийлэх тухай ойлголтыг сайжруулах сургалт, сурталчилгааны үйл ажиллагаатай холбож хэрэгжүүлэх
- **(Дэмжлэг үзүүлэх агуулга)** Эрүүл ахуйн үндсэн хэрэгслээр хангах, сурталчилгааны хуудас, материал хэвлэх, халдвараас сэргийлэх ойлголтыг нэмэгдүүлэх контент хийж цацах(сошиал нетворк, зурагт, радио гм)
- **Ажлын хуваарь болон агуулга**
 - (Хэрэгцээг судлах) Нийт 114 төсөл дунд Covid-19-ийн халдвараас сэргийлэхэд ашиглах хэрэгцээ шаардлагын судалгаа (2020.03.26 ~)
 - (Дэмжлэг үзүүлэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх) Төсөл хэрэгжилтийн хүрээнд болон нэмэлт сурталчилгааны ажлын төлөвлөгөөтэй холбон хэрэгжүүлэх ба ингэхдээ хамтын ажиллагаат улсын засгийн газрын бодлоготой нийцэж байх(2020.04.13 ~)
 - (Үр дүнг хянан шалгах) Тухайн хагас жил бүрийн төсөл хэрэгжилтийн өнөөгийн байдалд үндэслэн Covid-19-ийн эсрэг дэмжлэг үзүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг хянаж нэгдсэн байдлаар удирдан зохицуулалт хийх

□ **Шаардлагатай төсөв**

- **(Төсвийн нэр)** Хөгжлийн хамтын ажиллагаа ба хүмүүнлэгийн тусламж(Загсийн газрын санхүүжилт) - Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл(ODA) - Сэдэв тус бүрээр хэрэгжүүлэх хөтөлбөр
- **(Шаардлагатай төсөв)** 300 сая вон
 - Өөрийн төсвөөр хэрэгжүүлэх боломжтой

[12] [Иргэний нийгмийн хамтын ажиллагаа] Хөгжиж буй орнуудын социал интерпрайзуудыг яаралтай дэмжих

□ **Төслийн ерөнхий мэдээлэл**

- **(Төслийн нэр)** Covid-19-ийн улмаас үйл ажиллагаа нь суларсан хамтын ажиллагаат улсын социал интерпрайзын үйл ажиллагааг идэвхижүүлэх, хамтын ажиллагаат байгууллагыг дэмжих
- **(Төрөл)** Хамтын ажиллагаат шилдэг байгууллагыг бэлтгэн гаргах, жишиг төсөл (Нийгмийн эдийн засгийн инкубатор хөтөлбөрийг ашиглах)
- **(Зорилго)** Covid-19-ийн хөл хорио тогтоосон нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа нь суларсан хамтын ажиллагаат улс орнуудын нийгмийн эдийн засгийн зах зээлийг идэвхижүүлэх, социал интерпрайзуудын үйлдвэрлэлийг халдварт өвчинтэй тэмцэх ажилд чиглүүлэн нийгэмд оруулах хувь нэмрийг өсгөх
- **(Хамрах хүрээ)** Хамтын ажиллагаат орны 150 орчим социал интерпрайзууд
- **(Хэрэгжүүлэх хугацаа)** 2020 оны 4 сараас жил дуустал

□ **Ерөнхий агуулга**

- **(Дэмжлэг үзүүлэх арга)** KOICA + SVS(Korea Social Value and Solidarity Foundation) + KFTO(Korea Fair Trade Organization) + GSEF(Global Social Economy Forum) 4 талт MOU-г байгуулснаар сан үүсгэх, хамтын ажиллагаат улсын социал интерпрайзуудад нэн түрүүнд дэмжлэг үзүүлснээр нийгмийн тогтвортой байдлыг хангах
- **(Дэмжлэг үзүүлэх агуулга)** Нийт 150 социал интерпрайзад 10,000ам.доллар - 15,000 ам.долларын тусламж үзүүлснээр тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зориулсан бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг эрчимжүүлэх
- **Ажил хэрэгжүүлэх хуваарь, агуулга**

- (MOU) 4 байгууллага дотоод гадаадын социал интерпрайзуудыг дэмжих зорилгоор MOU байгуулсан (2020.04.20)
- (Хэрэгжүүлэх арга замыг хэлэлцэх) Нийгмийн эдийн засгийн инкубатор төслийг хэрэгжүүлэх байгууллага (Merry Year Foundation)-тай хамтран ажиллах арга замыг хэлэлцэн зохицуулалт хийсэн
- (Өөрчлөлт оруулах гэрээ) Сангаас олгосон төсвийн зарцуулалт, дэмжлэг үзүүлэх ажлууд(ажлын гүйцэтгэлийг удирдах)-ын талаар гэрээ(өөрчлөлт оруулсан) байгуулсан
- (Бүртгэл явуулж, сонгон шалгаруулах) Цаашид Covid-19-тэй тэмцэх, нийгмийн нэгдэл дээр суурилсан эдийн засгийн хөтөлбөрүүдтэй холбоход санхүүжилт хийх төслийг сонгох, хийгдэх ажлуудыг хянан шалгах
- (Үр дүнг тооцох) Хийгдсэн ажлуудын өнөөгийн нөхцөл байдал, нийгэмд оруулсан хувь нэмрийг тооцох, гүйцэтгэл, үр дүнг удирдах

□ **Шаардлагатай төсөв**

- **(Төсвийн нэр)** Хөгжлийн хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн тусламж(Засгийн газрын санхүүжилт) – Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл(ODA) – Шилдэг хамтрагчийг бэлтгэн гаргах, жишиг төсөл хөтөлбөр
- **(Шаардлагатай төсөв)** 1,6 тэрбум(Сангаас 1 тэрбум 500 сая + урсгал зардал 100 сая вон)

[13] [Хүмүүнлэгийн тусламж] Улаан загалмайн нийгэмлэг-иргэний нийгмийн хамтарсан хүмүүнлэгийн тусламж

□ **Төслийн ерөнхий мэдээлэл**

- **(Төслийн нэр)** Солонгосын улаан загалмайн нийгэмлэг(CU3H) болон иргэний нийгмийн Коронатай тэмцэх хамтарсан төсөл
- **(Хэлбэр)** Дотоодын иргэний нийгэмтэй хамтран хүмүүнлэгийн тусламж үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл
- **(Зорилго)**
 - Covid-19-ийн улмаас огцом өссөн Солонгосын иргэний нийгмээс хөгжиж буй орнуудад үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн хэрэгцээг хангах
 - Хөгжиж буй орнуудын засгийн газраас нэн түрүүн тусламж дэмжлэг авч чадахгүй цагаач, дүрвэгсдийн хуаран, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг зорилтот бүлэгт тусламж үзүүлэх шаардлагатай

□ **Ерөнхий агуулга**

○ **(Хийгдэх ажлууд)**

- Хөгжиж буй орны халдварт өвчинд амархан өртөх магадлалтай иргэд(цагаач иргэд, хүүхдүүд, эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг)-эд эрүүл ахуйн сургалт болон бүсийн нийгмийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх аян өрнүүлэх, эрүүл ахуйн хэрэгсэл(саван гм)-ээр хангах

- Өдөр тутмын ахуйн хэрэгсэл(эмэгтэйчүүдийн хэрэгсэл гм)-ээр хангах, сэтгэлзүйн эмчилгээ болон амьжиргаа залгуулах ажилд нь дэмжлэг үзүүлэр

○ **(Хамтран ажиллах байгууллага) СУЗН, дотоодын ТББ***

* Дотоодын ТББ : Манай засгийн газар болон орон нутгийн засаг захиргаанд бүртгэлтэй ашгийн бус байгууллага, хуулийн этгээд

○ **(Дэмжлэг үзүүлэх арга) KOICA-СУЗН хооронд байгуулсан MOU-р СУЗН төслийг хэрэгжүүлэхээр хариуцаж авсан**

- СУЗН болон төсөл хүлээн авагч улсад үйл ажиллагаагаа явуулж буй салбар Нийгэмлэгүүдтэй хэрэгжүүлж буй төслүүд

Ангилал	Урьдчилан бэлдсэн	Зарцуулах	Дахин сэргэх/ байдлыг намжаах	Нийт
Эрүүл мэнд (Ус, эрүүл ахуй)	1 тэрбум вон	3,5 тэрбум вон	500 сая вон	5 тэрбум вон
Амьжиргааг дэмжих	500 сая вон	1,5 тэрбум вон	1 тэрбум вон	3 тэрбум вон
Гамшгийн эрсдлийг бууруулах	400 сая вон	400 сая вон	200 сая вон	1 тэрбум вон
Захиргаа удирдлага	330 сая вон	330 сая вон	330 сая вон	1 тэрбум вон
Нийт	2 тэрбум 230 сая вон	5 тэрбум 730 сая вон	2 тэрбум 30 сая вон	10 тэрбум вон

- СУЗН – дотоод дахь иргэний нийгмийн хамтарсан төсөл : KOICA-СУЗН-КСОС(ОУ-ын хөгжлийн хамтын ажиллагааны хувийн хэвшлүүдийн холбоо)-тэй хамтын ажиллагаатай дотоодын иргэний нийгмийн Covid-19-тэй тэмцэх хөгжиж буй орнуудын хүмүүнлэгийн тусламжийн төсөл хөтөлбөрийн хэрэгцээнд чиглүүлэн хэрэгжүүлэх

※ Ихэнх дотоодын ТББ-ууд нь гадаадад салбар нэгж, харилцаа холбоогүй учир СУЗН-ийн гадаад дахь өргөн харилцаа холбоог ашиглах боломжтой

□ **Шаардлагатай төсөв**

- **(Төсвийн нэр)** Хөгжлийн хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн тусламж – Хүмүүнлэгийн тусламж(ODA)-Яаралтай аврах ажиллагаа
- **(Шаардлагатай төсөв)** 20 тэрбум вон *KOICA-гийн бусад төслийн санхүүжилтээс шилжүүлэх хэрэгжүүлэхээр төлөвлөж байна
- Нэмэлт төсөв хэрэгтэй

[14] [Судалгааны мэдээлэл] Covid-19-тэй тэмцэхэд чиглэсэн Солонгосын кэйс судалгаа

□ **Төслийн ерөнхий мэдээлэл**

- **(Төслийн нэр)** Covid-19-ийн тухай Солонгос улсын туршлагыг таниулахад чиглэсэн судалгаа
- **(Хэлбэр)** Судалгаа, тандалт
- **(Зорилго)** БНСУ-ын Covid-19-тэй тэмцсэн туршлагыг хуваалцсанаар хамтрагч улсуудад заавар сургамж болох, олон улсад өвчний тархалтыг бууруулахад хувь нэмэр оруулах
- **(Хамрах хүрээ)** Covid-19 тархсан хамтын ажиллагаат бүх улс орон
- **(Хэрэгжүүлэх хугацаа)** 2020 оны 4 сар – 8 сар

□ **Ерөнхий агуулга**

- **(Судалгааны агуулга)** Covid-19-тэй тэмцэх тухай 5 гол сэдвийн хүрээнд явуулсан судалгааны ажил

	Сэдэв	Агуулга
1	Хамтын ажиллагаат орнуудын халдварт өвчинтэй тэмцэх тогтолцооны өнөөгийн	-JEE, SPAR-г ашигласан улс тус бүрийн халдварт өвчинтэй тэмцэх тогтолцооны өнөөгийн байдал

	байдлын тухай судалгаа	
2	Корона-19: Ардчилсан засаглалын өнцгөөс харсан Солонгосын Корона-19-тэй тэмцэх тогтолцооны онцлог	- Нээлттэй, ил тод, ардчилал гэсэн 3 зарчимд тулгуурлан засгийн газрын засаглал талаас тэмцэх - Олон улсын нийгэм дэх харилцан туслалцаа, иргэний нийгмийн хамтын ажиллагаа
3	Корона-19: Солонгосын эрүүл мэндийн бодлого, эрүүл мэнд эмнэлгийн тогтолцооны өнцгөөс	- Өвчинтэй тэмцэх ажлын хэсэг ба удирдлагын тогтолцоо, эрүүл мэнд эмнэлгийн тогтолцоог ашиглан өвчинтэй тэмцсэн тухай кэйс(Оношилгооны тогтолцоо болон өвчтөнийг удирдан зохион байгуулах) - Олон улсын стандарт болон IHR-н хэрэгжүүлэлтийн асуудал ба Солонгосын өвчний эсрэг авах арга(Нээлттэй, ил тод, ардчиллын зарчмаар)
4	Корона-19: Эрүүл мэндийн нэгдэл(Health Communication) ба эрсдлийн удирдлагын өнцгөөс харах нь	-Солонгосын халдварт өвчний тухайд Эрүүл мэндийн нэгдэл(Health Communication) -ийн кэйс - Гадаад дахь халдварт өвчний Эрүүл мэндийн нэгдэл(Health Communication)-ийн кэйс
5	Корона-19: Мэдээлэл харилцааны технологид тулгуурласан халдварт өвчний удирдлагын өнцгөөс харах нь	- Шалгалт шинжилгээ, өвчин тархалтын судалгаа, оношилгоо шинжилгээ, эрсдлийн үеийн харилцаа холбоо/хяналтын тогтолцоо(хавьтагчдийг тооцох, зохицуулах) зэрэг ажилд мэдээлэл харилцаан технологийг ашигласан кэйс

※ Судалгааны ажлын дэлгэрэнгүй агуулга болон тоо ширхэгийг дараа өөрчилж болно.

○ **Хийгдэх ажлын хуваарь, агуулга**

	Төлөвлөлт(4-5 сар)	Хэрэгжүүлэлт(5-7 сар)	Нээх(8 сар)
Агуулга	<ul style="list-style-type: none"> • Судалгааны ажил хийх төлөвлөгөө гаргах • Судалгааны ажлыг хийх байгууллагыг сонгох 	<ul style="list-style-type: none"> • Судалгааны ажлыг явуулах 	<ul style="list-style-type: none"> • Судалгааны ажлыг орчуулж хэвлэх • Судалгааны ажлын тайланг танилцуулах, түгээх

□ **Шаардлагатай төсөв**

○ **(Төсвийн нэр)**

- 130 сая вон : Хамтарсан төслийн санхүүжилт – Хамтарсан төслийн санхүүжилт(ODA)-Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх(Салбар бүрт мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх) – Салбар тус бүрт стратеги боловсруулж, модул гаргах

- 20 сая вон : Авсан төсөл – Төр хувийн хэвшлийн түншлэлийн олон улсын өвчинтэй тэмцэх ажиллагаа – Төсөл хөгжүүлж, удирдан зохион байгуулах зардал

○ **(Шаардлагатай төсөв)** 150 сая вон

- Нэмэлт төсөв хэрэгтэй (+150 сая вон)

[15] [Судалгааны ажлын мэдээлэл] Covid-19-тэй тэмцэх онлайн консолтинг

※ Хэрэгжүүлэх дэлгэрэнгүй арга замын талаар зөвшилцөж байна.

□ Төслийн ерөнхий мэдээлэл

○ **(Төслийн нэр)** Covid-19-тэй тэмцэх онлайн консолтинг

○ **(Хэлбэр)** Вэбсайт, мэдлэгийн төв(Knowledge hub), нийгмийн сүлжээ зэрэг онлайн платформыг ашиглан бичлэг байрлуулах

○ **(Зорилго)** Хөгжиж буй орны төрийн албан хаагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн Covid-19-тэй хэрхэн тэмцэх тухай мэдээллээр хангах хэрэгцээ шаардлагыг судлах, нийтлэг асуултуудыг тусгасан дүрс бичлэг байрлуулж, шуурхай зохицуулалт хийх нөхцлийг бүрдүүлэх

○ **(Хамрах хүрээ)** Covid-19 бүртгэгдсэн хамтын ажиллагаат бүх улс орон

○ **(Хэрэгжүүлэх хугацаа)** 2020 оны 4 сар – 8 сар

□ Дэлгэрэнгүй агуулга

○ **(Дэмжлэг үзүүлэх арга)** Төлөөлөгчийн газруудаараа дамжуулан хөгжиж буй орнуудын хэрэгцээг судлах, глобал хамтын ажиллагааны эмч мэргэжилтнүүдийн холбоо харилцаанд тулгуурласан судалгаагаар Covid-19-тэй хэрхэн тэмцэх тухай асуултууд болон нийтлэг асуултуудыг нэгтгэн боловсруулсны дараа дотоодын халдварт өвчний мэргэжилтнүүдтэй холбосон дүрс бичлэг(5минутаас хэтрүүлэлгүй) хийж, цацах

○ **(Дэмжлэг үзүүлэх агуулга)** Ариутгал халдваргүйжүүлэлт – оношилгоо – эмчилгээний явцад үүсч болох аюулгүй байдлын удирдлага, оношилгооны арга, өвчний шинж тэмдэг болон кэйс, шинжилгээний хариуг мэдэгдэх, эмчилгээ зэрэг судалгаагаар гарч ирсэн нийтлэг асуултуудын талаар дотоодын халдварт өвчний эмч мэргэжилтнүүдийн өгөх хариултыг тусган дүрс бичлэг хийх

○ **Ажлын хуваарь, агуулга**

- (Судалгаа) Хамтын ажиллагаат улс бүрээр асуултуудыг судлах, глобал хамтын ажиллагааны эмч мэргэжилтнүүдийн харилцаа холбоонд тулгуурлан хөгжиж буй орнуудад нийтлэг тохиолдох асуултуудыг урьдчилан судлаг(4 сарын дундаас эхлэн байнга)

- (Нийтлэг асуултуудын жагсаалт гаргаж мэргэжилтэн урих) Асуултуудыг сонгох, түүнд тохирсон дотоодын эмч мэргэжилтнүүдийг урьж оролцуулах(тогтмол)

- (Дүрс бичлэг хийх) Мэргэжилтэнтэй хамтран дүрс бичлэгийн зураг авч, хадмал бичиг оруулах зэрэг (тогтмол)

- (Дүрс бичлэг тараах) Онлайн платформыг ашиглан тухайн хамтын ажиллагаат улсад зориулсан дүрс бичлэгийг оруулж, цацах

□ **Шаардлагатай төсөв**

- **(Төсвийн нэр)** Тогтоогүй(хэлэлцэж байгаа)
- **(Шаардлагатай төсөв)** 100 сая вон(урьдчилсан байдлаар)

[16] [Хөгжлийн албан ёсны тусламж буюу ODA-ийн сургалт] Дэлхийн иргэний боловсролд суурилсан олон улсын эв нэгдлийг бэхжүүлэх хөтөлбөр

① **Дэлхийн иргэний боловсрол сэдэвт инноваци уралдаан шинээр явуулах**

- **(Төслийн нэр)** Дэлхийн иргэний боловсрол сэдэвт инноваци уралдаан
- **(Хэлбэр)** Өсвөр залуус(ахлах ангийн сурагчид)-т зориулсан дэлхийн иргэний боловсрол инноваци уралдаан
- **(Зорилго)** Covid-19-ийн цаг үеийн тогтвортой хөгжлийн зорилтууд(SDGs) болон үндсэрхэг үзэл, үзэн ядалт-ялгаварлан гадуурахалт, тахал-цаг уурын өөрчлөлт зэрэг дэлхий нийтийн асуудлуудыг шийдвэрлэх дэлхийн иргэний эв нэгдлийг бий болгох инноваци боловсролыг гаргаж ирэх
- **(Хамрах хүрээ)** БНСУ-ын өсвөр залууст зориулан дэлхийн иргэний боловсролыг явуулдаг хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагууд
- **(Хэрэгжүүлэх хугацаа)** 2020 оны 4 сар ~ 11 сар
- **(Хэрэгжүүлэх арга)** Уралдаанаар дамжуулан байгууллагыг сонгож, гэрээ хийсний дараа дэлхийн иргэний боловсролын хэрэгжүүлэх

Өмнө нь КОЙКА-гаас хэрэгжүүлж байгаагүй инноваци аргаар Covid-19-ийн цаг үед дэлхийд эв нэгдлийг бататгах сургалтын контентийг өөртөө агуулсан байгууллагыг сонгож өсвөр залуус(ахлах ангийн сурагчид)-т дэлхийн иргэний боловсролыг явуулна.

□ **Шаардлагатай төсөв**

- (Төсвийн нэр) Хамтын ажиллагааны төсөл - Хамтын ажиллагааны төсөл(ODA) - Сургалт судалгаа
- (Шаардлагатай төсөв) 80 сая вон
: Өөрийн төсвөөр хэрэгжүүлэх боломжтой

② К-МООС зэрэг онлайн сургалтыг өргөжүүлэх

- (Төслийн нэр) К-МООС зэрэг онлайн олон улсын хөгжлийн хамтын ажиллагаа-дэлхийн иргэний боловсрол сургалт
 - (Хэлбэр) Насанд хүрэгчидд болон өсвөрийнхөнд(ахлах ангийн сурагч) зориулсан оолн улсын хөгжлийн хамтын ажиллагаа-дэлхийн иргэний боловсрол
 - (Зорилго) Covid-19-ийн улмаас хэрэгжүүлэх боломжгүй байгаа нийтийн боловсролыг орлуулж, ард иргэдийн дэлхийн эв нэгдлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд олон улсын хөгжлийн хамтын ажиллагаа, дэлхийн иргэний боловсрол олгох сургалтыг явуулах
 - (Хамрах хүрээ) Солонгос улсын иргэд, өсвөр залуус
 - (Хэрэгжүүлэх хугацаа) 2020 оны 4 сар – 2021 оны эхний хагас жил
 - (Хэрэгжүүлэх арга) Уралдаан зарлаж, гэрээ байгуулан онлайн сургалтыг хөгжүүлэх байгууллагыг сонгох
 - (Төслийн агуулга) К-МООС, Youtube, Sigongmedia зэрэг онлайн хэрэгслүүдийг ашиглан сургалтын шинэ хөтөлбөр боловсруулах
- Эрүүл мэнд-боловсролын хичээл, тогтвортой хөгжлийн зорилтууд хичээл, дэлхийн иргэний боловсролын хичээл гм

□ **Шаардлагатай төсөв**

- (Төсвийн нэр) Хамтарсан төсөл – Хамтарсан төсөл(ODA)- Сургалт судалгаа
- (Шаардлагатай төсөв) 350сая вон

: Өөрийн төсвөөр хэрэгжүүлэх боломжтой

*Нийт 430 сая вон

2. [Дунд болон урт хугацааны] Цаашид хэрэгжүүлэх чиглэл

1 Зорилтот улс оронд үзүүлэх эрүүл мэндийн салбарын дэмжлэг

□ Оношилгооны бие даасан чадамжийг эзэмшихэд дэмжлэг үзүүлэх

○ (Гол агуулга) Хөгжиж буй орнуудад халдварт өвчнийг оношлох чадавхыг бэхжүүлэх

○ (Хэрэгжүүлэлтийн арга) Хөгжиж буй орнуудын эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд халдварт өвчний эсрэг хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх сургалт, зөвлөгөөний дэмжлэг үзүүлэх

▶ Зайлшгүй шаардлагатай мэргэжлийн ур чадвар олгох сургалтын хөтөлбөрөөр хангах болон (on-off line) сургалт явуулах

▶ Олон улсын нийгэмлэгийн мэргэжилтнүүдтэй холбоо тогтоож хариу арга хэмжээний талаар хуваалцах

▶ Халдварт өвчинтэй тэмцэх мэргэжилтэн бэлтгэж томилох

□ Эмчилгээний эм, вакцины хангамжийг дэмжих

○ (Гол агуулга) Дэлхийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран эмчилгээний эм, вакцинаар хангах

○ (Хэрэгжүүлэлтийн арга) Дэлхийн эрүүл мэндийн байгууллагууд болон эрүүл мэндийн судалгаа, үйлдвэрлэлийн байгууллагуудын хамтын ажиллагааны тусламжтайгаар эмчилгээний эм болон вакцинаар хангах

▶ Халдварт өвчний эсрэг тогтвортой хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээ болох урьдчилан сэргийлэх вакциныг бүтээн олон нийтэд түгээх

▶ Эмчилгээний эм болон вакциныг базааж зорилтот улс орнуудад үзүүлэх дэмжлэгийг өргөжүүлэх

□ Зорилтот бүлгийн сэргэлтийг өргөн хүрээнд дэмжих

○ (Гол агуулга) Нийгмийн сэргэлтийг дэмжих хөтөлбөр

○ (Хэрэгжүүлэлтийн арга) Post Covid-19 хөгжиж буй орнуудын зорилтот бүлгийн эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн салбар дахь дэмжлэг болон биеэ даах чадварыг бэхжүүлэх

- ▶ Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлж нийгмийн бүх салбарт (эрүүл мэнд, боловсрол, төрийн удирдлага гэх мэт) хамгааллын сүлжээг өргөжүүлэх, альтернатив функцийг хадгалах, хэрэгжүүлэх үндэс суурийг бий болгох
- ▶ Хөдөө аж ахуй, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн чилэлээр төсөл хэрэгжүүлэгчдэд зориулан бичил зээл, шинэлэг технологид суурилсан санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- ▶ Хөгжиж буй орнуудын нийгэм, эдийн засгийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, эдийн засаг сэргэснээр тогтвортой ашгийг шударга хуваарилж ашиглахыг дэмжих
- ▶ Дэвшилтэт санхүүгээр дамжуулан гэнэтийн гамшгийн эрсдэлийн үед амьжиргааны дэмжлэг үзүүлэх

② Халдварт өвчний менежментийн чадавхыг бэхжүүлэх

□ **Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төслийг боловсруулах болон хэрэгжүүлэх**

- (Үндсэн агуулга) Хөгжиж буй улсын ЭМ-ийн системд халдварт өвчнөөс сэргийлэх тогтолцоог бий болгох.
- (Хэрэгжүүлэх арга) Бүс нутаг, улсаар нь ангилан ЭМ-ийн тогтолцоо болон ЭМ-ийн байгуулагыг дэмжих

- ▶ ЭМ-ийн байгууллагын удирдах газрын бодлогыг засварлах болон журмыг шинэчлэх
- ▶ Төсөл хэрэгжих ЭМ-ийн байгууллагад тоног төхөөрөмж болон техникээр хангах
- ▶ Халдварт өвчнөөс сэргийлэх олон улсын ЭМ-ийн байгууллагатай хамтран ажиллах(CEPI, WHO, GAVI, Global Fund, Unitaid)
- ▶ ЭМ-ийн салбарын мэргэжилтэн бэлтгэх(KCDC, Улсын төв эмнэлэг, Johns Hopkins, ОУБ зэрэг мэргэжлийн хүний нөөцтэй байгууллагуудтай хамтран мэргэжилтэн бэлтгэх), мэдлэг хуваалцах, хил гаалийн халдваргүйжүүлэлтийг сайжруулах
- ▶ БНСУ-ын ТББ болон тус улсын ЭМ-ийн байгууллагын хамтын ажиллагаагаар ЭМ-ийн үйлчилгээг сайжруулах
- ▶ Тус улсын ТББ, ЭМ-ийн байгууллагын яаралтай үеийн хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх болон бүсийн нийгмийн тогтолцоог бий болгох
- ▶ ЭМ-ийн анхан шатны эрсдлийг бууруулах зориулалттай ус, ариун цэврийн холбогдолтой төсөл хэрэгжүүлэх
- ▶ Бүс нутагт ЭМ-ийн үндсэн тогтолцоог дэлгэрүүлэх болон CHW зэрэг мэргэжлийн чадварыг сайжруулах
- ▶ Сайн дурын ажилтнууд болон тэдгээрийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах
- ▶ Яаралтай тусламжийн эм, эмийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэх

□ **Халдварт өвчнийг урьдчилан илрүүлэх чадахыг бэхжүүлэх болон халдварт өвчний эсрэг хамтран тэмцэх тогтолцоог бий болгох**

- (Үндсэн агуулга) ЭМ болон халдварт өвчний үндсэн мэдээллийг үүсгэх болон хянах төсөл.
- (Хэрэгжүүлэх арга) Халдварт өвчнийг хянах үндсэн мэдээллийг цуглуулах болон R&D-ийг ашиглах ашиглалтын системийг үүсгэх

- ▶ Олон улсын хамтын ажиллагаа(Хөгжиж буй улс, Хөгжингүй улс, ОУБ) болон ирэгний нийгмийн хамтын ажиллагаагаар дамжуулан үндсэн мэдээллийг цуглуулах, байгалийн, эдийн засгийн нөхцөл байдалд нь тохирсон халдварт өвчний үр нөлөөний зэргийг мэдэх болон тухайн шинж чанарт нь тохирсон арга хэмжээг авах аргыг хөгжүүлэх
- ▶ Халдварт өвчний тандалт судалгаа болон эрт илрүүлэх чадавхыг бэхжүүлэх
- ▶ Халдварт өвчний тандалт судалгааг хянах нэгдсэн системийг хөгжүүлэх
- ▶ Уур амьсгалын өөрчлөлт болон хүн төрөлхтөний амьдрах орчны өөрчлөлтөөс үүссэн халдварт өвчин, байгаль орчноо хамгаалахтай уялдуулах
- ▶ Гадаад дотоодын эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран глобал нийтийн үйлчилгээг судлах
- ▶ Хөгжиж буй орны судалгааны байгууллагын бие даан судлах чадварыг дэмжих

□ **Халдварт өвчинд хариу арга хэмжээ авах үндсэн суурийг бий болгох**

- (Үндсэн агуулга) Олон салбарынхан хамтран арга хэмжээ авах болон эрсдэлийг хянах чадавхыг бэхжүүлэх.
- (Хэрэгжүүлэх арга) Эрүүл мэндийн салбар, Төрийн захиргаа, Иргэний нийгмийн нягт харилцаагаар дамжуулан халдварт өвчинтэй тэмцэх тогтолцоог бий болгох.

- ▶ ЭМ-ийн байгууллага, систем, Хил нэвтрэн гарах(Хүн ам, судалгаа, халдваргүйжүүлэлт) болон нийтийг хамарсан бодлого системийг хөгжүүлэх
- ▶ Эрсдэлийг хянах зориулалтаар цахим иргэний бүртгэлийн системийн төслийг уялдуулах болон ашиглах
- ▶ Эрсдэлтэй холбогдолтой ил тод, шуурхай байдлыг нэвтрүүлэх, аюулгүй байдлын зааварчилгааг түгээх системийг хөгжүүлэх
- ▶ Халдваргүйжүүлэх болон эрсдэлд бэлтгэгдсэн хүний нөөцийг бэлтгэх, чадавхыг бэхжүүлэх
- ▶ Мэргэжилтнүүдийг бүрэн дайчлах зориулалттай мэргэжлийн багийг бэлтгэх
- ▶ (Бүс нутаг) Иргэний нийгмийн эрүүл мэндийн сайн дурын ажил, зорилтот бүлэгт чиглэсэн яаралтай тусламжийн ажлын тогтолцоог бүрдүүлэх

3 (БНСУ-ын туршлагыг ашиглан глобал хамтын ажиллагааг бэхжүүлэх)

□ Нэгдмэл шинж чанартай халдварт өвчтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх

- (Үндсэн агуулга) Халдварт өвчтэй тэмцэх БНСУ-ын хөтөлбөрийг дотоодчлох
- (Хэрэгжүүлэх арга) COVID-19 бүрэн эдгэрсэн үед дэвшилтэт технологийг ашиглан халдварт өвчний эсрэг хариу арга хэмжээ авах төслийн загварыг бий болгох

- ▶ ШУТ-ийн нийгэмлэг(судалгааны байгууллага) + ЭМБ + Холбогдолтой аж ахуйн нэгж хамтран олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны загварыг бий болгох
- ▶ БНСУ-ын COVID-19-тэй тэмцсэн загвар болон системийг ашиглан бусад улсын онцлогт нийцүүлж бодлого болон тогтолцоог шинэчлэх
- ▶ COVID-19 бүрэн эдгэрсэний дараа нийгэмд гарах өөрчлөлтөд нөлөөлөх эрсдэлийг тооцох, тохирсон арга хэмжээг олон улсын нийгмийн харилцаанд хуваалцах
- ▶ Хөгжиж буй улс + Хөгжингүй улс + ОУБ + БНСУ-ыг хамарсан хамтын судалгааны тогтолцоог бүрдүүлэх, хамтдаа тэмцэх аргыг судлах
- ▶ Хөгжиж буй улсын судалгааны байгууллагыг дэмжин ажилласнаар тухайн улсын чадавхыг бэхжүүлэх(Илүү дээр ирээдүйн төлөө ахлах сургуулийн боловсролыг дэмжих төсөлтэй уялдуулах)

□ Олон улсын иргэний хамтын ажиллагаа болон глобал платформыг идэвхжүүлэх

- (Үндсэн агуулга) Уур амьсгалын өөрчлөлт, халдварт өвчний тархалт зэрэг хил хязгааргүй аюулын эсрэг тэмцэхийн тулд хамтын ажиллагаа, хичээл зүтгэл хэрэгтэй
- (Хэрэгжүүлэх арга) Олон улсын иргэний нийгэм болон хамтын ажиллагааг тэлэх, ялгаварлан гадварлах, үзэн ядах үзлийг байхгүй болгох.

- ▶ Олон улсын иргэний боловсролыг шинэчлэх болон тэлэх
- ▶ Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэрлэх, халдварт өвчнөөс сэргийлэх зэрэг хамтдаа тэмцэж үр дүнг бий болгохын тулд хамтын нийгэмлэгийг байгуулж, хяналтыг сайжруулах хэрэгтэй
- ▶ ЭМ-ийн салбар бодлогын хүрээнд олон улсын иргэний нийгэм дэх бодлогын чиглэлээр хамтран ажиллах аргыг бий болгох
- ▶ Сэтгэл зүйн талаас эмчлэх зорилготойгоор сэтгэлзүйн эмчилгээний салбарынхны хамтын ажиллагааг идэвхжүүлж иргэний нийгэмд эмчилгээг нэвтрүүлэх

□ Дэвшилтэт технологийг ашиглан хөгжиж буй улсуудад дэмжлэг үзүүлэх

- (Үндсэн агуулга) Дэвшилтэт технологт тулгуурласан халдварт өвчинтэй тэмцэх хамтарсан төслийг хэрэгжүүлэх
- (Хэрэгжүүлэх арга) Дэвшилтэт технологийг хөгжүүлэх болон ашиглалтыг нэмэгдүүлэх зорилготой дотоод болон гадаадын хамтарсан төслийг уялдуулах.

- | |
|--|
| <ul style="list-style-type: none">▶ Гадаад дотоодын ЭМ-ийн салбарын дэвшилтэт технологийг хөгжиж буй улсын халдварт өвчнөөс сэргийлэх төсөлтэй уялдуулах▶ Хөгжлийн хамтын ажиллагааг ашиглаж болох технологийн судалгааг дэмжих + ЭМАБ-ын салбарын үйлдвэрлэлийг уялдуулах(Хувийн санхүүжилтийг татах) + олон улсын хөгжлийн хамтын ажиллагаагаар дамжуулан БНСУ-ын туршлагын нийлмэл чанарыг идэвхжүүлэх▶ Хөгжиж буй улсын халдварт өвчнөөс сэргийлэхэд ашиглах технологийг хөгжүүлэх болон олон улсаас санхүүжилт татах ажлыг уялдуулах▶ Дэвшилтэт технологиор бүтсэн бүтээгдэхүүнийг ашиглан бүсийн нийгэмд тулгуурласан зорилтот бүлгийг дэмжих төслийг хэрэгжүүлэх |
|--|